



**МОНГОЛ ХЭЛНИЙ НЭГДСЭН АГУУЛГААР ШАЛГАХ  
ШАЛГАЛТЫН СЭДЭВ**  
/ 11-р анги/

**Хувилбар А**  
**ДААЛГАВАР. НИЙТ 40 ОНОО**

**Хугацаа 80 минут**

Эхийг анхааралтай уншиж даалгаврыг гүйцэтгэнэ үү.

**ХҮН УУСАХАЙ**

1. “Хүн уусчихдаг юм” гэвэл хэнбугай ч итгэхгүй биз. “Элсэн чихэр юм уу давс л уусдаг биз дээ. Хүн арай ч тэгж уусах юм уу?” гэж бас асууцгаана. Гэтэл хүн бас уусчихдаг юм байна. Уусах уусахдаа давс шиг усанд уусчихдаг юм биш байна. Хүн уусах дөрөв таван янзын хэлбэр байдаг юм ажээ. Тэдгээрийг санаандгүй хэрэглэчихээс гадна санаатай хэрэглэх тохиолдол ч элбэг байна.
2. **Хүнс тэжээлгүй бол хүн амьд явах аргагүй.** Хүнс гэвэл юуны урьд ус зэргийн шингэнийг ууж цангаагаа тайлдаг. Гэвч усыг ургамлын навчтай хамт чанаж ууж сураад түүнийгээ “цай”, “tea”, “чай” гэхчлэн нэрлээд уудаг болсон. Тэгснээ өөр нэг ургамлаар ундаанд амт нэмдэг болж “кофе” гэж нэрлэв. Цайнд орчихсон хүн бол тэр ундаанаасаа элдэв гэм авах нь бараг үгүйтэй адил. Харин кофе гэдэг ундаанаас бол зүгээр өнгөрөх нь ховор ажээ. Их кофейчин Италид эрдэмтэд судалгаа хийсэн чинь генийг өөрчлөн донтуулдаг болсон нь тодорхой болсон байна. PDSS2 гени нь кофенд орчихсон хүнийг зүгээр суулгахгүй тамхичинтай адил байн байн уух болгодог тэр нь яваандаа биед нь гэм тавьдаг байна. Монголчууд бол харин малынхаа сүүг айраг болгон иsgэж уудаг олон zuуны уламжлалтай боловч өрнөдийн шар айрагт сүүлийн үед бас амтших болов. Нэг үгээр хэлэхэд ус, сүүн тэжээлээр амьд явахад хангалттай боловч хүн гэгчийг даврах сэргээлгээ, шунал нь хүнийг аажмаар уусгаж үгүй болгох гашуудалт төгсгөл рүү хөтөлсөөр байна.
3. **Хүн төрөлхтөн бол мөн чанартаяа махчин хамтлаг юм.** Өнөө үед мах иддэггүй иргэдтэй улс бараг байхгүй. Тэд ан амьтдыг агнаж иднэ. Мал өсгөж түүнээ нядалж иднэ. Монголчууд саяхан болтол хоёр төрлийн хоол тэжээлтэй байлаа. Зун, намрын улиралд “цагаан хоол” хэрэглэдэг байв. Хонь, ямаа, үхрийн голдуу махан хүнсийг өвөл, хаврын хүйтэн улиралд хэрэглэдэг өвөрмөц хоолтой байлаа. Гэвч 20-р зууны эхээр өрнөдийн хоол хүнсэнд орж уусан идээших үйл явц өрнөсөн тул бие мах өөрчлөгдөхгүй ч гэсэн түүнийг тэжээх хүн нь өөрчлөгдөхөөр барахгүй өдөрт нэг биш гурван удаа хольцтой хоол барих зантай болж тиймэрхүү явдал дассан бараг дөрөв дэх үеийнхэн одоо нэгэнт төрж гарчхаад байна. Хүнсэндээ уусаж үгүй болох аюултай. Аль хэдийнээ халз тулгарчхаад байна. Худлаа гэвэл Монгол улсын иргэд элгэний өвчлөлөөр дэлхийд тэргүүлж эхэллээ. Монголын хүн амын тэн хагас нь суудаг нийслэлийн гуанз, дэлгүүр, хоолны газруудад зарж буй хүнсний зүйлд 97 төрлийн нэмэлт ашигладаг нь шалгалтаар илэрхий болжээ. Энэ бүхний 80 хувь нь “Хүнсний өрнөхий стандарт” -д огт тусгагдаагүй бүтээгдэхүүн байсан байна. Ийм их хорт бодис хатуу хяналтгүй бол юунд ч хүргэж, “хүн амины” хэрэг тарихаас болгоомжлох учиртай.

Л. Түдэв

**НЭГ. МОНГОЛ ХЭЛНИЙ ДААЛГАВАР:** Нийт 26 оноо

1. Дараах өгүүлбэрийг гол гишүүдээр зурж, ямар нехцэлөөр холбогдоноыг тэмдэглэж, ямар өгүүлбэр болохыг тодорхойлно уу. \ 4 оноо\

Хүнс гэвэл юуны урьд ус зэргийн шингэнийг ууж, цангаагаа тайлдаг.

2. Эхээс зэрэгцсэн нийлмэл үг 4-ийг олж бичнэ үү. \ 4 оноо\

--	--

3. Эхийн 2 дахь цогцолборын тодруулсан өгүүлбэрийн үгсийг эсрэг утгатай үгсээр солин найруулж бичнэ үү. \ 4 оноо\

---

---

---

4. Зөв бичгийн дүрэм \ 4 оноо\

- "өөрчлөгдөхөөр" гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу. \ 3 оноо\

---

---

---

- "Эгшгээр тэгссөн үгийн араас урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад "н" гийгүүлэгчийг жийрэглэнэ" гэсэн дүрэмд тохиорох үгийг дээрх эхийн 2 дахь цогцолбороос олж бичнэ үү. \ 1 оноо\

---

---

5. Дээрх эхийн гол санааг илэрхийлж, орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж, үйл явдлыг 180- 250 үгэнд багтаан найруулга зүйн алдаагүй, гаргацатай цэвэрхэн, дүрмийн алдаагүй, хүүрнэн бичнэ үү. \ 10 оноо\

ХОЁР. УРАН ЗОХИОЛЫН ДААЛГАВАР: Нийт 9 оноо

1. Цэгийн оронд тохиорох үгийг нөхж бичээрэй. \ 2 оноо\

..... шүлэг нь ..... мөрт, гүн ухааны утга агуулгатай, онч мэргэн санаатай шүлгийг хэлэх ба ..... , ..... гэсэн хатуу тогтсон загварын холбоцтой байдаг.

2. Хайку шүлгийг дуурайн, байгалийн элдэв үзэгдлийг ажиглаж мэдэрснээ бичнэ үү. \ 2 оноо\

---

---


3. А.П.Чехов "Хамелеон" өгүүллэгийн бүтцийг зөв харгалзуулна уу. \ 5 оноо\

№	Үйл явдлын тухай	Үсэг	Өгүүлэгдэхүүний бүтэц
1.	Эхлэл	А.	Генералын дүүгийн нохой гэдгийг мэдсэн ...
2.	Зангилaa	Б.	Хэний нохой болохыг тогтоох гэж маргалдацаасан ...
3.	Өрнөл	В.	Зээлийн орчин байдлыг дүрсэлсэн ...
4.	Түйл	Г.	Нохойд хазүүлсан хүн гарч ирсэн ...
5.	Тайлал	Д.	Байцаагч тушмэл Очумелов маргааныг эцэслэж чадалгүй польтогоо өмсөж сандарч байгаа ...

Хариулт: 1....., 2....., 3....., 4....., 5.....

**ГУРАВ. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ДААЛГАВАР. Нийт 5 оноо**

1. Эхийг орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлнэ үү.



.....

.....

.....

.....

.....

.....

**ХҮҮРНЭСЭН ЭХ БИЧИХ ХЭСЭГ:**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**МОНГОЛ ХЭЛНИЙ НЭГДСЭН АГУУЛГААР ШАЛГАХ****ШАЛГАЛТЫН СЭДЭВ****/ 11-р анги/****Хувилбар Б****ДААЛГАВАР. НИЙТ 40 ОНОО**

Эхийг анхааралтай уншиж даалгаврыг гүйцэтгэнэ үү.

**ХОВС****Хугацаа 80 минут**

Болжмор шувуу газраас хэдэн алд хэрийн өндөрт яг л эрвээхэй шиг дэрвэгнэн далавчаа түргэн мөртлөө тэрүүхэнд нь дэвэн хаашаа ч нисэхгүй тогтчихсон юм шиг тормойж байлаа. " Аав аа, тэр нэг бялзуухай яж байгаа юм бэ?" гэж би ааваас гайхан асуусан чинь аав түүнийг харангaa: " Ээ харла аа! Одоо яана аа! гэж дуу алдav. Аав миний саравчтай малгайг яахын зуургүй эргэлдүүлэн шидэв. Малгай минь тоглоомын жалан дугуй шиг эргэлдсээр өнөөх агаарт тогтчиоод эрвэлзэж байсан болжморын доохнуур өнгөрөн, цаахна нь уналаа. Тэрхэн мөчид болжмор уяа нь тайлагдсан юм шиг гялсхийн нисэж одов. Үүнд би маш их гайхан алмайрсан боловч малгайнхаа хойноос гүйлээ. Аав хойноос хүрч ирээд " Энүүхэнд могой байгаа түүнд гишгүүлчихвэл молцогт цагаан шиг болно шүү." гэж сануулав. Молцогт цагаан гэдэг хүзүүндээ хоёр молцогтой цагаан ямаа байлаа. **Тэр нэг өдөр хонины түрүүнд ороод өвс сорчилж явсан молцогт цагаан ямаа маань гэнэт муухай дуугаар дуугаар тэр дордоо эргэлдэж эхэлсэн юм.** Түүний эрүү нь хавдаж тэр дордоо нэг нүд нь анилдаж наалдаад тун удалгүй толгой нь хавдаж аймаар юм болж билээ. Тэрхэн зуурт сүргээс нь салгаж, буцааж хотонд нь оруулаад шар сүүнд толгойг нь булхуулж булхуулж, шар сүүнд дүрсэн таараар пэндийтэл боосон юм. Гэвч тус болсонгүй молцогт цагаан минь маргааш нь нүд анъж билээ. **Түүнээс хойш могойноос их айдаг болсон юм.** Аав сахлаг өвс рүү заахад тэр зүг харвал өвсөн дундуур хар эрээн дээс шиг юм мурилзан далд орохыг үзэв. Малгай маань ч тэрүүхэнд хэвтэж байв. Би түүнийг авахаас зүрхшээн зогсож байтал аав малгайг шүүрэн аваад, " нэг бялзуухайн амь аварсан буянтай малгай ариудаа биз" гэснээ шившээд толгой дээр минь тавив. " Аав аа, та яагаад малгайг ииш нь шидчихэв ээ" гэж асуувал " Тэр болжмор хий агаарт хадагдчихсан юм шиг дэрвээд хөдөлж чадахгүй байгаа биз дээ. Хэрвээ жаахан л удсан бол тэр хаашаа ч нисэж чадахгүй, дошилсоор газар байсан могойн аманд орж, залгиулах нь гарцаагүй байсан. Могой газарт хэвтээд, толгойгоо жаахан цогнойлгоод агаарт нисэж буй болжморыг нүд салгалгүй ширтдэг юм. Голио, дэвхрэг олж идэхээр намхан, доогур нисэж явсан болжмор могойн нүдтэй халз тааралдвал өөр тийшээ нисэж чадахаа болж дошилсоор байгаад залгиулдаг. Хэрэв заяа тэр хоёрын дундуур өөр нэг юм орвол шиরтсэн харцаа алдаж салцигаадаг. Тэгээд могойд ховсдуулсан болжморын дундуур малгайгаа шидэх юм уу, уургаар хөндлөн гаргавал тэд хагацаж буян болдог гэдэг дээ" гэж ярив. Ийм нэгэн явдал багад болж билээ. **Гэвч ховс гэдэг хачин ойлголт жилээс жилд гайхаш төрүүлсээр өнөө үед улам сонирхууштай үзэгдлийн нэг болжээ.** Хүн хүнээ ховсдох үзэгдэл улам бүр газар авч 21-р зуунд түгээмэлд хэрэглүүр болж магадгүй.

Л. Түдэв

1.

- Дараах өгүүлбэрийг гол гишүүдээр зурж, ямар нэхцэлөөр холбогдоноыг тэмдэглэж, ямар өгүүлбэр болохыг тодорхойлно уу. \ 4 оноо\

Аав миний саравчтай малгайг яхын зуургүй эргэлдүүлэн шидэв.

2. Эхийн тодруулсан хэсгээс угсарсан нийлмэл үг 4-ийг олж бичнэ үү. \ 4 оноо\

--	--

3. Эхийн төгсгөл дэх тодруулсан өгүүлбэрийн онцолсон үгсийг ойролцоо утгатай үгсээр солин найруулж бичнэ үү. \ 4 оноо\
- .....  
.....  
.....  
.....

4. Зөв бичгийн дүрэм \ 4 оноо\

- “доошилсоор” гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу. \ 3 оноо\
- .....  
.....  
.....  
.....

- “ Гийгүүлэгчээр төгссөн үгийн араас урт эгшгээр эхэлсэн бүтээвэр залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ.” гэсэн дүрэмд тохирох үгийг дээрх эхийн онцолсон өгүүлбэрээс олж бичнэ үү. \ 1 оноо\
- .....  
.....

5. Дээрх эхийн гол санааг илэрхийлж, орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж, үйл явдлыг 180- 250 үгэнд багтаан найруулга зүйн алдаагүй, гаргацтай цэвэрхэн, дүрмийн алдаагүй, хүүрнэн бичнэ үү. \ 10 оноо\

#### ХОЁР. УРАН ЗОХИОЛЫН ДААЛГАВАР: Нийт 5 оноо

1. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй. \ 2 оноо\

Хайку шүлэг нь ....., ..., тав буюу арван долоон ..... бүтэцтэй бөгөөд заавал ..... аль нэгийг төлөөлсөн үг орсон байх ёстой.

2. Хайку шүлгийг дуурайн, байгалийн элдэв үзэгдлийг ажиглаж мэдэрснээ бичнэ үү. \ 2 оноо\
- .....  
.....  
.....


3. Алфонс Доде “ Сүүлчийн хичээл” өгүүллэгийн бүтцийг зөв харгалзуулна уу. \ 5 оноо\

№	Үйл явдлын тухай	Үсэг	Өгүүлэгдэхүүний бүтэц
1.	Эхлэл	А.	Хичээлийн үйл явц ...
2.	Зангилаа	Б.	Франц мандугай! ...
3.	Өрнөл	В.	Амель багшийн сэтгэл хөдөлж, хоолой чичрч, хүүхдүүд үйлмаар ч, инээмээр ч байсан ...
4.	Түйл	Г.	Зарлалын самбарын зарлал ...
5.	Тайлан	Д.	Сургууль руу явж байгаа нь ...

Хариулт: 1....., 2....., 3....., 4....., 5.....

## ГУРАВ. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ДААЛГАВАР. Нийт 5 оноо

1. Эхийг орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлнэ үү.



---

---

---

---

---

---

---

## ХҮҮРНЭСЭН ЭХ БИЧИХ ХЭСЭГ:

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---